

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД БӨГӨӨД ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН АЙМАГ,
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН "ЗАСГИЙН ГАЗРЫН ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ
ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ" 2022 ОНЫ ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

№	Шалгуур үзүүлэлт	Биелэлтийн хувь	Шалтгаан
3.2. Засаг дарга нь суралцагч, иргэнд тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр дор дурдсан үүрэг хүлээнэ.	3.2.16. Хууль тогтоомжид заасан онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд багшаар үндсэн чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтод үл хамаарах ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхгүй байх;	100	Бүтэн жилийн байдлаар Багшийн албан тушаалын тодорхойлолтод үл хамаарах ажил, үйлчилгээ гүйцэтгүүлсэн санал, гомдол, мэдээлэл ирээгүй болно.
	3.2.17. Багш, удирдах ажилтны мэдээлэл холбооны технологи ашиглах чадвар, цахим контент бэлтгэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын байран дээрээ хөгжих орчныг бүрдүүлэх, “Багш хөгжлийн төв” - д дэмжлэг үзүүлэх;	100	e-mongolia-аас зохион байгуулсан төрийн албан хаагчдын мэдээлэл технологийн мэдлэг чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд интернэтийн хэрэглээ, нууцлалын систем, word, excel, powerpoint-ийн ахисан шатны сургалтуудад БШУГ-ын албан хаагчид хамрагдаж тестийн шалгалт өгч мэдлэгээ бататгасан. Мөн боловсролын мэдээллийн технологийн төвөөс зохион байгуулсан 2 удаагийн сургалтад хамрагдаж medle.mn хаягтай хэрхэн ажиллах, office 365-ийн хэрэглээний сургалтад 490 багш хамрагдсан байна. Мэдлэ.мн платформд ээлжит хичээлийн цахим контент байршуулах, ашиглах сэдэвт сургалтыг Сайнцагаан сумын

			ЭДЦС-ийг түшиглэн 103, Эрдэнэдалай суманд 158, Цагаандэлгэр суманд 12 мэргэжлийн багш нийт 273 багш нарыг сургалтад хамруулан цахим контент боловсруулах чадварыг нэмэгдүүлсэн байна. ЕБС-ийн Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн улсын хэмжээнд багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа цахимд шилжиж Aplus платформд Боловсролын ерөнхий газраас зарласан 111 модулийн зорилтот болон сонголтод сургалтад аймгийн нийт багш нарын 93 хувь буюу 494 багш хамрагдан мэдлэг боловсролоо ажлын байрнаасаа дээшлүүлсэн байна. Давхардсан тоогоор оролцогчдын тоо-1157 Аймгийн хэмжээний нийт 19 сургуулийн 52 хувь буюу 10 сургууль “Багш хөгжлийн төв”-ийг өмнөх жилүүдэд байгуулж, 2021-2022 оны хичээлийн жилд Өндөршил, Баянжаргалан сумын ЕБС-иуд “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн 82.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгээр “Багш хөгжлийн төв”-ийг
--	--	--	--

			шинээр байгуулсан нь багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлсэн хөрөнгө оруулалт болов.
	3.2.18. Багшийг ээлжит хичээлийн цахим контент бэлтгэх ажилд идэвхтэй оролцуулахад дэмжлэг үзүүлэх, ахлах ангийн суралцагчдыг цахим сургалтын системээр сонгон суралцах боломжийг бүрдүүлэх;	100	БШУГ-ын даргаар “Цахим контент-2022” арга хэмжээний удирдамжийг боловсруулан батлуулж, тус арга хэмжээнд аймгийн 19 сургууль, 22 цэцэрлэг 100 хувийн ирцтэй оролцож, цэцэрлэгийн бүлгийн болон сургуулийн 632 мэргэжлийн багш нарын 33 хувь буюу 210 багш нар цахим контентыг баг, хамт олноороо бэлтгэн амжилттай оролцож эхний байруудад шалгарсан 48 цахим контентод арга технологийн сангийн гэрчилгээг олгон, цэцэрлэгийн болон ЕБС-ийн мэргэжлийн 422 багш нарт арга туршлагыг түгээн дэлгэрүүлж, харилцан туршлага солилцлоо. Мэдлэ.мн платформд аймгийн 19 сургуулийн 29 багш бие даан болон багаараа 16 нэгжийн 122 цагийн ээлжит хичээлийн цахим контентийг болдовсруулан байршуулж, 38 багш багаар хамтран 14

			нэгжийн 120 цагийн ээлжит хичээлийг боловсруулах эрх авсан нь багш нарын багаар мэргэжлийн хөгжлийн бүлгээр хамтран ажиллах чадварт суралцаж байгаагийн үр дүн гэж үзэж байна. Цахим сургалтын elab.mn сайтад хамрагдан 189 сурагч математик, монгол хэл, нийгэм, англи хэл, физик, хими нийт 6 судлагдахуунаас өөрийн сонирхсон нэг хичээлийг, “Багшийн туслах 800” сайтад өөрийн сонирхлоор Хүмүүнлэг сургуулийн 12-р ангийн 15 сурагчид, аймгийн БДБ-ын 10-р ангийн 163 суралцагч мэдлэ.мн цахим сургуульд суралцан аймгийн мэргэжлийн 3 багш цахим сургуулийн багшаар ажиллаж, цахим орчинд сургалтын үйл ажиллагаа явуулахад суралцаж байна.
	3.2.19. Орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын статистик мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж, холбогдох хууль, дүрэм, журамд заасан хугацаанд тайлагнах;	100	Сургуулийн ном сурах бичиг, сургалтын орчин, төсөв санхүү, хүний нөөц, сурагчдын статистик мэдээ, Цэцэрлэгийн сургалтын орчин, ундны ус ариун цэврийн байгууламж, төсөв санхүү, хүний нөөц, хүүхдийн статистик мэдээ

			тайланг хугацаанд нь 100 хувь тайлагнасан. Статистик мэдээ захиргааны маягтаар 65 төрлийн мэдээг цаг хугацаанд гаргаж хүргэсэн байна.
3.3. Засаг дарга нь боловсролын салбарт менежмент, хүний нөөц, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр дор дурдсан үүрэг хүлээнэ.	3.3.7. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын мэдээлэл, холбооны дэд бүтэц, сүлжээний төхөөрөмж, шилэн кабелийн ашиглалт үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, сайжруулах;	100	Ерөнхий боловсролын 19 сургууль өндөр хурдын шилэн кабелийн интернэтэд холбогдсон. Монголын цахилгаан холбоо компаниас Гурвансайхан сумын ерөнхий боловсролын сургууль хурдаа сайжруулж авч байгаа бусад 18 сургуулийн интернэт саадгүй Яамнаас өгсөн Эрдэмнетиin урсгалыг авч ажиллаж байна. Сургууль 100 хувь интернэт ажиллаж байгаа. 22 цэцэрлэг, Насан туршийн боловсролын төв нийт интернэтэд холбогдсон байгууллага 100 хувь болсон байна. Гэвч цэцэрлэг, насан туршийн төв интернэтийн урсгалын хурд удаан, тавигдсан төсөв бага байдгаас 3 цэцэрлэг нэмэлтээр өөрсдийн нөөц боломжоор гэр интернэт, модем ашиглан интернэт ашиглаж байна. Сүлжээний тархацыг сайжруулж дотоод сүлжээний утас татах болон wifi төхөөрөмж байршуулж багш бүрд

			интернэт хүргэсэн сургуулиуд 12 байна. Багш нарын 50 хүртэлх хувийн интернэтийг хангасан 7 сургууль байна. Сайнцагаан сумын 5-р цэцэрлэг, 8-р цэцэрлэгийг шилэн кабелид холбосон. 42 байгууллагын шилэн кабелийн оролт 97,6 хувьтай байна. 2022 онд сайжруулалт хийгдсэн 2 цэцэрлэг, 2 сургууль нийт 4 байна.
3.5. Засаг дарга нь боловсролын салбарын санхүү, төсвийн удирдлага, хэрэгжилтийн чиглэлээр дор дурдсан үүрэг хүлээнэ.	3.5.4. Боловсролын салбарын төсвийн шинэчлэл, цахим шилжилттэй холбоотой үйл ажиллагааг дэмжиж ажиллах, холбогдох тооцоо судалгаа, цахим төсвийн төслийн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах;	100	Боловсролын салбарын албан хаагч нарт төсвийн шинэчлэлийн бодлогыг таниулах, хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, ойлголт мэдээллийг нэгтгэх, шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхээр БШУСайдаар ахлуулсан ажлын хэсэг 05 сарын 13-14 өдрүүдэд ажиллан, уулзалтад 300 багш ажилтан, сургалтад 200 багш ажилтан хамрагдлаа. Сургууль, цэцэрлэгээс байгууллагын удирдлага, сургалтын менежер, арга зүйч, нягтлан бодогч ЗАН-ын ахлагч багш нарын бүрэлдэхүүнтэй оролцлоо. Сургууль, цэцэрлэгийн 2023 оны төсвийн төслийг цахим программд шивж оруулахаар

			байгууллагын дарга, нягтлан бодогч нарыг арга зүйгээр ханган 100 хувь цахимаар төсвийн төслийг боловсруулан хуулийн хугацаанд хүргүүлээ. Төсвийн шинэчлэлийг орон нутагт хэрэгжүүлэх ажлаар Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нягтлан бодогч, нярав нарыг чадавхижуулах сургалтыг танхимаар зохион байгуулж, бүх сумдад зөвлөн туслах ажлаар очиж ажиллалаа. 2022 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг цахимд оруулж хяналт тавьж ажиллаж байна. Төсвийн шинэчлэлээр шинээр хэрэгжүүлж буй зардлуудын хэрэгжилтийг байгууллага бүрээр гарган цахим хурлаар байгууллагын дарга, нягтлан бодогч нарт танилцуулан зардлуудыг бүрэн зарцуулах тал дээр хамтарч ажиллалаа.
--	--	--	--